



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20 21 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/187

Арвайхээр

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг Өлзийтийн 1 дүгээр гудамж 118 тоотод 1271м² газрыг Эрүүл мэндийн газар (РД9045716)-т эрүүл мэндийн байгууллагын зориулалтаар 60 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрх авсан байгууллагатай газар эзэмших гэрээг байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2009 оны 235 дугаар захирамжийн аймгийн Эрүүл мэндийн газар (РД9045716)-т холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  А.ИШДОРЖ



011100486